

САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ОНОЛЫН АСУУДЛУУД

Д.Моломжамц*, **Б.Хишигдэлгэр****, **Э.Ундармаа*****

Хураангуй: Аж ахуйн нэгж, байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийг хөтлөх явцад бэлтгэгдсэн, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой ихээхэн хэмжээний тоо, мэдээллийг удирдлагын шийдвэр гаргахад шуурхай ашиглах нэг чухал арга зам бол санхүүгийн шинжилгээ хийх явдал юм. Өөрөөр хэлбэл санхүүгийн шинжилгээг аж ахуйн нэгж, байгууллагад бүртгэлийн процедурыг хэрэгжүүлэх явцад буй болсон “түүхий мэдээ” – г боловсруулж мэдээлэл бэлтгэх үйл явц гэж хэлж болно. Харин энэхүү “боловсорсон мэдээлэл” – ээр хэрэглэгч субъектүүдийг шуурхай хангахын тулд санхүүгийн шинжилгээг тодорхой дэс дараалал, арга зүйн системийг ашиглах нь явдал чухал ач холбогдолтой.

Энэхүү өгүүлэлд манай улсад үүсч, хөгжиж ирсэн аж ахуйн үйл ажиллагааны болон санхүүгийн шинжилгээний хөгжлийг түүхчлэн авч үзэхийн зэрэгцээ эдийн засгийн мэдээллийн системд шинжилгээний гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар авч үзсэн болно.

Түлхүүр үгс: санхүүгийн шинжилгээ, санхүүгийн тайлангийн шинжилгээ, санхүүгийн шинжилгээний төрлүүд

A STUDY OF THE THEORY OF FINANCIAL ANALYSIS

Abstract: Financial analysis is an important way for businesses to use large amount of data that was prepared in the accounting recording of business and organizations to make management decision. In other words, financial analysis is the information preparation process to use “raw data” which was created during the implementation of accounting for business entities and organizations. Instead, it is the important to use right sequence and methodology of financial analysis to provide information users with processed information quickly. This article provides a historical overview of the development of business operation and financial analysis that has formed and developed in our country, as well as the role and importance of analysis in economic information systems.

Key words: financial analysis, financial statement analysis, types of financial analysis,

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E mail): molomjams0112@yahoo.co.jp

** МУИС-ийн ШУС, Хүмүүнлэгийн ухааны салбар, (E mail): mongoliabkd@gmail.com

*** МУИС-ийн Бизнесийн сургууль, (E mail): undarmaa.enhee@yahoo.com

Оршил

Шинжилгээ нь эрт дээр үеэс хүн төрөлхтний шинжилэх ухааны танин мэдэхүйн болон практик үйл ажиллагааны үндэс суурь болж өргөн цар хүрээтэй ойлголтыг агуулсаар ирсэн. Шинжилгээ нь тухайн судалж буй объектийг тодорхой элемент хэсгүүдэд хуваах, задлах гэсэн утгатай Грекийн “Analisis” гэдэг үгнээс гаралтай. “Analisis” нь диалектикт судалж байгаа объектын өмнө нь задлан хуваасан элементүүдийг нэг зорилгоор нэгтгэх гэсэн утгатай синтез буюу “Sinthesis” гэсэн урвуу ойлголттой хамтдаа хэрэглэгддэг.

Шинжлэх ухааны мэдлэгийн аль ч салбарт улс төр, нийгэм-эдийн засаг, экологи, соёл ахуй зэрэг хүмүүсийн үйл ажиллагааны аль ч хүрээнд анализ-синтезгүйгээр хандах боломжгүй. Эдийн засагт анализ-синтезийг хэрэглэснээр бид оршин байгаа юмс үзэгдэл, эдийн засгийн шийдвэрлэгдээгүй олон асуудал, зорилтуудыг шийдвэрлэх боломжтой болно. Эдийн засаг хэр зэрэг амжилттай хөгжих нь юуны түрүүнд улс төр, экологи, социологи, соёл зэргийг хэр гүнзгий судалж, танин мэдэх, учир шалтгааныг тодорхойлохоос ихээхэн хамаарна. Иймээс анализ-синтез нь байгаль-нийгмийн үзэгдэл, үйл явцыг танин мэдэх шинжлэх ухааны арга, хүн төрөлхтний сэтгэлгээний агуулга ба хэлбэр болдогт оршино.

Шинжилгээг гүйцэтгэх арга болон танин мэдэхүйн явцад ашиглаж байгаа хийсвэрлэлтийн түвшин, судалж байгаа объектийн шинж чанар, түүний бүтцийн нарийн түвэгтэй байдал зэргээс хамаарч нийгмийн шинжлэх ухааны судалгаа шинжилгээ нь байгалийн шинжлэх ухааныхтай төстэй байдаг. Эдийн засгийн шинжилгээ нь субъектив хүчин зүйл болон эдийн засгийн бодит хуулийн нөлөөлөл дор бүрэлдэн бий болсон эдийн засгийн үзэгдэл, үйл явцын судалгаатай холбоотой тусгай мэдлэгийн системийг агуулж байдаг.

Зах зээлийн харилцааг төгөлдөржүүлэн гүнзгийрүүлэхэд юуны түрүүнд микро түвшин буюу аж ахуйн нэгжийн хүрээнд болон түүний дотоод нэгж хэсэг, бүтцийн түвшинд эдийн засгийн шинжилгээг хөгжүүлэх шаардлагатай. Учир нь эдгээр анхан шатны нэгж, хэсгүүд нь өмчийн хэлбэрээсээ үл хамааран зах зээлийн эдийн засгийн үндэс, суурь нь болж байдагтай холбоотой.

1. Санхүүгийн шинжилгээний үүсэл, хөгжил

Нягтлан бодох бүртгэлийн данс ба дансны давхар бичилтийн аргыг 13-р зууны үед үүссэн гэж үздэг бол бүртгэл, тайлангийн тоо мэдээг шинжлэх арга зүй түүнээс даруй 400-гаад жилийн хойно үүсэж хөгжсөн байдаг.

Эдийн засгийн шинжилгээг нягтлан бодох бүртгэлийн бүрэлдэхүүн элемент болох талаас нь анх системчилж үндэслэсэн хүн бол Францын эрдэмтэн Жак

Савари (1622-1690) юм. Түүний “Хураангуй ба дэлгэрэнгүй бүртгэлийн тухай ойлголт” хэмээх бүтээлийг удирдлагын бүртгэлийн анхдагч бүтээлүүдийн нэг гэж үздэг. Тухайн үед Францаас гадна бусад улс орнуудад, тухайлбал Италид эдийн засгийн шинжилгээний тодорхой чиглэлээр судалгаа хийгдэж байв. Италийн эрдэмтэн А.Пиетро төсвийн санхүүжилтийг гүйцэтгэлийн бодит зардалтай нь харьцуулах арга зүйг судалж байсан бол судлаач Б.Вентури аж ахуйн үйл ажиллагааны 10 хүртэлх жилийн үзүүлэлтүүдийн динамик эгнээг үүсгэх, түүнийг шинжлэх арга зүйг авч үзэж байв.

Францын эрдэмтэн Ж.Саваригийн санааг XIX зуунд Италийн нягтлан бодогч Жузеппе Чербони (1827-1917) нягтлан бодох бүртгэлийн дансдыг синтезлэн нэгтгэх ба задлан шинжлэх тухай сургаалийг үндэслэх замаар улам гүнзгийрүүлэн хөгжүүлсэн хэмээн үздэг. Хэдийгээр нягтлан бодох бүртгэлийн шинжлэх ухаан үүсэж хөгжөөд олон зуун жил өнгөрсөн ч дөнгөж XIX зууны сүүлч, XX зууны эхээр бүртгэлд баланс судлалын тухай ойлголт гарч ирсэн гэж үздэг. Үүнийг дараах гурван үндсэн чиглэлээр хөгжсөн гэж судлаачид тайлбарладаг. Үүнд:

1. Балансын эдийн засгийн шинжилгээ
2. Балансын хуулийн шинжилгээ
3. Хэрэглэгчдийн дунд балансын талаарх мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зэрэг болно.
 - Эхний чиглэлийг хөгжүүлэхэд Швейцарийн эрдэмтэн И.Шерийн 1925 онд хэвлүүлсэн “Нягтлан бодох бүртгэл ба баланс”, Германы эрдэмтэн П.Герстнерийн 1926 онд хэвлүүлсэн “Балансын шинжилгээ”, Америкийн эрдэмтэн Ж.Блиссийн “Үйлдвэрийн газрын аж ахуйн үйл ажиллагааны үзүүлэлтүүд” хэмээх бүтээлүүд ихээхэн хувь нэмэр оруулсан байна. Тухайлбал, П.Герстнер балансын шинжилгээний онцлогийн талаар судалж, урт болон богино хугацаат өр төлбөрийн харьцаа, зээлийн хөрөнгийн дээд хязгаарыг тодорхойлох арга зүй, санхүүгийн тогтвортой байдал болон төлбөрийн чадвар хоорондын харилцан уялдаа холбоо зэргийг судалж байсан.
 - Хоёрдугаар чиглэлийг хөгжүүлэхэд Р.Байгель, Э.Ремер, К.Порциг зэрэг Германы эрдэмтэд гол үүрэг гүйцэтгэсэн байдаг. Тэд пүүс компаниуд тайлан балансыг бэлтгэхдээ хуулийн дагуу, тогтоосон хэм хэмжээг баримтлахын чухлыг онцолж байв. Түүнчлэн энэ чиглэлийн хүрээнд нягтлан бодох бүртгэлийн онол, практикийн зарим асуудлыг засварлах ёстой хэмээн үзэж байсан.

- Гуравдугаар чиглэлийг мөн Германы эрдэмтэд хөгжүүлсэн бөгөөд тэдгээрээс Брозиус, Губер, Шенвандт нарыг онцлог авч үздэг. Тэд тайлан баланс нь үнэн бодитой байхаас гадна заавал тайлбартай байх ёстой гэж үзсэн.

Орос улсад XX зууны эхний хагаст балансын шинжилгээ үүсэж хөгжсөн гэж үздэг. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотойгоор эдийн засгийн шинжилгээний гүйцэтгэх үүргийг анх удаа үнэлсэн хүн бол Оросын анхны нягтлан бодогч хэмээн тооцогддог А.К.Рощаховский юм. Түүнчлэн 1920-иод онд баланс бэлтгэх арга зүй, тухайлбал балансын шинжилгээний арга зүйг нилээд цэгцтэй томъёолсон хүмүүс бол А.П.Рудановский, Н.А.Блатов, И.Р.Николаев нарын эрдэмтэд, мэргэжилтнүүд байв. Харин тус улсад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн жилүүдэд аж ахуйн үйл ажиллагааны дотоод болон зэрэгцүүлсэн шинжилгээ давамгайлж ирсэн байна. Энэ үед төлөвлөгөөнөөс хэлбэлзсэн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн шинжилгээ зонхилж, хяналтын функц нь хүчтэй болж улмаар санхүүгийн удирдлагын хэрэгсэл болсон балансын ач холбогдол буурсан нь социалист эдийн засгийн тогтолцооны үед гарах ёстой зүй ёсны үзэгдэл байлаа.

Чухам энэ үед манай оронд аж үйлдвэрийн үндэс суурь тавигдаж үүнтэй холбоотойгоор шинжлэх ухааны үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийг хэрэглэж эхэлсэн нь манай улсад анхнаасаа аж ахуйн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах агуулгатай дотоод шинжилгээг хөгжүүлж ирсэнийг харуулж байна.

Санхүү, эдийн засгийн шинжилгээг нягтлан бодох бүртгэлээс тусгаарлахын хэрээр түүний санхүүгийн орчин доройтож үнэн хэрэгтээ техник-эдийн засгийн шинжилгээ /хөдөлмөр цалин хөлс, үйлдвэрлэлт, борлуулалтын үзүүлэлтүүдийн шинжилгээ гэх мэт/ болж хувирсан. Ийм шинжилгээ нь гол төлөв хяналтын үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ өмнөх жилүүдийн мэдээллийн баазад хандсан байдаг учраас үр дүн багатай байв. 1940-өөд оны эхээр үйлдвэрийн газрын аж ахуйн үйл ажиллагааны дотоод шинжилгээгээр С.К.Татур, Д.П.Андрианов, М.Ф.Дьячков, М.И.Баканов нарын анхны бүтээлүүд гарч эхэлсэн. Түүнчлэн 1940-өөд оны сүүлчээр социалист систем бүрэлдэн тогтсонтой уялдаж аж ахуйн үйл ажиллагааны дотоод шинжилгээг социалист орнуудын эрдэмтэд судалж эхэлсэн байна.

Тухайлбал, Болгарын эрдэмтэн Тото Тотев, Чехословакийн эрдэмтэн Иржи Клозар, БНАГУ-ын эрдэмтэн Ульрика Штрассбургер нарыг дурьдаж болно.

Улмаар 1970-аад онд аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээний онолоор ЗХУ-ын эрдэмтэд болох М.И.Баканов, А.Д.Шеремет, И.И.Каракоз,

Н.В.Дембинский нарын анхны ном сурах бичгүүд хэвлэгдсэн байна.

Манай улсад 1924 онд анх удаа нягтлан бодогчийн дамжааг зохион байгуулжээ. ЗХУ-ын мэргэжилтэн А.Д.Грижавскийн удирдлага дор БНМАУ-ын Сангийн яамны хэлтсийн эрхлэгч Н.Лувсансодном, нягтлан бодогч Ч.Түмэн нар 1924 онд төсвийн байгууллагуудын хяналт шалгалт ба нягтлан бодох бүртгэлээр арга зүйн заавар боловсруулсан нь манай улсад анх удаа бүртгэл, шинжилгээний чиглэлээр хэвлэгдсэн баримт бичиг байлаа. Үүний дараа 1949 оны 9-р сард Ч.Түмэн “Үйлдвэрийн нягтлан бодох бүртгэлийн сурах бичиг” номыг хэвлүүлсэн нь Монгол хэл дээр бичигдсэн нягтлан бодох бүртгэлийн анхны бүтээл байсан бөгөөд 1949 оны 11-р сард ЗХУ-ын мэргэжилтэн А.А.Юрковтай хамтран түүний уншсан лекцүүдэд тулгуурлан “Нягтлан бодох бүртгэлийн үндэснүүдийн сурах бичиг” хэмээх номыг хэвлүүлсэн байна.

Нягтлан бодох бүртгэлд тусгах үзүүлэлтүүдийн талаар Ч.Түмэн өөрийн бүтээлдээ “...Тайлангийн тодорхойлогч ба маягтууд нь оновчтой бөгөөд цөөн байх хэрэгтэй. Үүнд тэрхүү байгууллагын үйлдвэрлэлийн программ, үйлдэхүүний төлөвлөгөөт өөрийн өртөг, үйлдвэрлэлийн зардлууд, хөдөлмөрлөх хүчний хангалт, ашиглалт, хөдөлмөрийн бүтээл, үйлдэхүүний борлуулалтуудын зэрэг бүх төлөвлөгөөний биелэлт хийгээд, хөрөнгийн ашиглалт ба санхүүгийн байдал зэрэг бас бус чухал эдийн засаг, санхүүгийн талаар холбогдсон тоо, төлөвлөгөөний мэдээ баримтуудыг тодорхойлсон үзүүлэгчүүд байвал зохино...” гэж тодорхойлон бичжээ. (Түмэн, 1949) Ингэж манай улсад шинжлэх ухааны үндэслэлтэй нягтлан бодох бүртгэл үүсч хөгжсөн нь бүртгэлийн мэдээ тайланд тулгуурлан санхүүгийн шинжилгээг хийх боломж бүрдсэн гэж үзэж болно.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн он жилүүдэд аж ахуйн үйл ажиллагааны дотоод шинжилгээг өөрийн орны нөхцөл байдалд тохируулан ашиглаж үүнтэй холбоотой онол, практикийн судалгааг манай улсын олон эрдэмтэд тухайн үеийн ЗХУ-ын эрдэмтэд, мэргэжилтнүүдтэй хамтран хийж байв. Үүний нэг жишээ бол 1957 онд хэвлэгдсэн Ч.Түмэн, Л.Занабазар нарын “Үйлдвэрийн газрын аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ” гэдэг ном бөгөөд энэ нь манай улсын хувьд шинжилгээний чиглэлээр бичигдсэн анхны бүтээл байлаа. Үүний дараа аж ахуйн үйл ажиллагааны дотоод шинжилгээний чиглэлээр 1959 онд Л.Лхамсүрэн, С.М.Мирощенко нарын “Аж үйлдвэрийн аж ахуй санхүүгийн ажиллагааны шинжилгээ ба шалгалт”, 1966 онд С.Лодой, С.Цэвээнпүрэв нарын “Үйлдвэрийн газрын бүтээгдэхүүний өөрийн өртөг, санхүүгийн байдлын шинжилгээ”, 1984 онд Ж.Аюурзана, А.Дамдинсүрэн, О.Чимэд нарын “Аж үйлдвэрийн газрын аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд хийх шинжилгээ”, 1986 онд Ж.Аюурзана, Г.Бямбацэрэн, С.Цогсүрэн нарын “Тайлан баланс,

түүнийг удирдлагад хэрэглэх нь” зэрэг бүтээлүүд хэвлэгдсэн гарсан байна. Эдгээр бүтээлүүдэд социалист аж ахуйн төлөвлөгөөний биелэлтэнд нөлөөлсөн хүчин зүйлийг шинжлэх техник, эдийн засгийн шинжилгээний арга зүйг гол төлөв авч үзсэн байдаг.

Аж ахуйн үйл ажиллагааны дотоод шинжилгээний зорилгыг “Аж ахуйн ажил явуулгын шинжилгээ нь аж ахуйн байгууллагын ажиллагаа ба төлөвлөгөөний биелэлтийг тэр газрын бүртгэлийн материалуудыг төлөвлөгөөт үүргүүдтэй зэрэгцүүлэн үзэх замаар шинжилж, ялангуяа төлөвлөгөөний биелэлтийн зөрүү ба төлөвлөгөөг биелүүлсэнээс гарсан үр дүнг харуулахын хамт мөнхүү төлөвлөгөөг биелүүлэх ба давуулан биелүүлэхэд нөлөөлсөн сайн ба муу талын шалтгаан нөхцлүүдийг илрүүлж түүнд зохих дүгнэлт хийж, тэр байгууллагын ажиллагаанд үнэлэлтийг өгөх ёстой” (Түмэн ба Занабазар, 1957) гэж тодорхойлсон байна.


Үүний зэрэгцээ санхүүгийн шинжилгээний зарим нэг арга зүйг социалист эдийн засгийн онцлогт тохируулан авч үзэж байсныг дурьдах нь зүйтэй. “Хэрэв балансанд бэлтгэн нийлүүлэгчид ба банк, улсын төсөвт төлөх хугацаа хэтэрсэн өргүй байвал түүнийг төлбөрийн чадвартай гэж зүй ёсоор үзэх ба хугацаа хэтэрсэн өртэй бол төлбөрийн чадвар муутайд тооцно”, “Ойрын үед /долоо ба арав хоног, сар/ төлбөрийн чадвар ямар болохыг судлан шинжлэхдээ төлөх хугацаа ойртсон бүх төлбөрүүд, бэлэн байгаа ба орох хөрөнгүүдийг тооцоонд авах хэрэгтэй. Хэрэв төлбөр ба орлого нь тэнцэж байвал төлбөрийн чадвар хэвээр үлдэнэ” (Лхамсүрэн ба Мироценко, 1959) гэх зэргээр дүгнэсэн байдаг.

Дээрх байдлаас үзвэл социализмын он жилүүдэд манай улсад аж ахуйн үйл ажиллагааны дотоод шинжилгээ нилээд эрчимтэй хөгжиж тодорхой түвшинд хүрсэн гэж дүгнэж болно.

Харин 1990 оноос буюу Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж эхэлснээс хойш манай улсын нягтлан бодох бүртгэл, шинжилгээний салбарт томоохон өөрчлөлт гарч Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу бүртгэлийг шинэчилж эхэлсэн. Тухайлбал, 1993 онд анх удаа “Нягтлан бодох бүртгэлийн тухай” Монгол улсын хууль, 1997 онд “Аудитын тухай” Монгол улсын хуулийг тус тус батлан гаргасан. Түүнчлэн 1995 онд “Нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар, санхүүгийн тайлан гаргах аргачлал”-ыг шинэчлэн боловсруулсан зэрэг нь манай улсын бизнесийн байгууллагуудын бүртгэл тайлангийн тоо мэдээ, түүнийг бэлтгэх болон боловсруулах арга зүйг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх, улмаар боловсронгуй болгох эхлэлийг тавьсан юм.

2. Мэдээллийн системд санхүүгийн шинжилгээний эзлэх байр суурь

Мэдээллийн систем гэдэг нь мэдээг боловсруулж мэдээлэл бэлтгэх үйл явц юм. Өөрөөр хэлбэл тоо, баримт, дүрс, тэмдэгт бүхий мэдээ буюу орцыг ашиглан боловсруулалт хийж хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл бэлтгэдэг. /Зураг 1/



Бүртгэлийн мэдээллийн систем нь удирдлагын мэдээллийн системийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Бүртгэлийн мэдээллийн систем нь дотоод гадаад хэрэглэгчдийг нягтлан бодох бүртгэлийн мэдээллээр хангах үүрэгтэй. Харин удирдлагын мэдээллийн систем нь объектын тухай мэдээг хүлээн авч удирдлагын зорилгын үүднээс боловсруулан удирдуулах объектод нөлөөлөх хэлбэрээр дамжуулдаг байна. Удирдлагын мэдээллийн систем нь дараах дөрвөн дэд системээс бүрддэг. /Хүснэгт 1/

Хүснэгт 1. Удирдлагын мэдээллийн систем

Систем	Мэдээ	Мэдээлэл
Маркетинг	Борлуулалтын тоо хэмжээ, бүтээгдэхүүний загвар	Борлуулалтын судалгаа
Бүртгэл, санхүү	Зээлийн хүү, ногдол ашиг, үнэ, ханш	Төлбөрийн тэнцэл, авлагын дундаж наслалт
Хүний нөөц	Цалин хөлс, ажлын цаг ашиглалт	Цалингийн сангийн мэдээлэл
Үйлдвэрлэл	Түүхий эд материал, тоног төхөөрөмж, тоо хэмжээ, өртөг	Үйлдвэрлэлийн тоо хэмжээ


Удирдлагын функцэд төсөвлөлт, зохион байгуулалт, захирамжлал, идэвхжилт, манлайлал, уялдуулалт, хяналт, харилцаа холбоо, шинжилгээ, үнэлгээ, шийдвэр гаргалт, ажиллагчдын шилэн сонголт, төсөөлөл, гэрээ хэлэлцээр зэрэг олон үүргийг хамааруулж авч үздэг. Эдгээрээс хамгийн чухал нь шийдвэр гаргалт юм. Менежерүүд шийдвэр гаргахын тулд мэдээллийг ашигладаг. Удирдлагын шийдвэр гаргахын өмнөх тодорхойгүй байдлыг аль болох багасгаж байвал тухайн мэдээлэл нь төдий чинээ үнэ цэнэтэй болно. Иймээс

үнэ цэнэтэй, чанартай мэдээлэл бэлтгэх явдал бол мэдээллийн системийн чухал зорилт бөгөөд энэ нь мэдээллийн систем дэх мэдээ боловсруулалтын үйл явцаас хамаардаг. Харин санхүүгийн шинжилгээ нь нягтлан бодох бүртгэлийн үр дүнд бэлтгэгдсэн ихээхэн хэмжээний тоо мэдээг боловсруулж удирдлагыг үнэ цэнэ бүхий шуурхай мэдээллээр хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул мэдээллийн системд онцгой байр суурь эзэлдэг байна. Мэдээллийн систем дэх мэдээ боловсруулалтын үйл явц нь хэд хэдэн үе шатыг дамждаг. Үүнд: а/. Цуглуулах, б/. Боловсруулах, в/. Бэлтгэх, г/. Шинжлэх зэрэг болно.

Үүнээс үзвэл шинжилгээ нь мэдээллийн систем дэх мэдээ боловсруулалтын эцсийн үе шат бөгөөд удирдлагын шийдвэр гаргахад шаардлагатай, үнэ цэнэтэй хэрэгцээт мэдээллийг бэлтгэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ утгаараа санхүүгийн шинжилгээ нь удирдлагын мэдээллийн системийн нэг дэд систем болох бүртгэлийн мэдээллийн системд багтаж удирдлагын функцуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Санхүүгийн шинжилгээ нь тоо мэдээг иж бүрэн системтэй ашиглахын зэрэгцээ нягтлан бодох бүртгэл, статистик, төлөвлөлт, математик болон бусад шинжлэх ухаануудад хэрэглэгддэг судалгааны арга хэрэгслийг өргөн ашигладаг. /Зураг 2/

Зураг 2. Эдийн засгийн мэдээллийн системд санхүүгийн шинжилгээний эзлэх байр суурь



Санхүүгийн шинжилгээ нь аж ахуйн бүртгэлийн нэг төрөл болох статистик бүртгэлтэй ихээхэн холбоотой. Нэг талаас статистикийн бүртгэл тайлан нь шинжилгээнд зориулагддаг бөгөөд нягтлан бодох бүртгэлийн нэг адил шинжилгээний мэдээллийн баазыг бүрдүүлдэг. Нөгөө талаас бүлэглэх болон зэрэгцүүлэх арга, индекс, корреляци, регресс зэрэг статистикийн олон аргуудыг шинжилгээнд хэрэглэснээр түүний арга зүйн системийг баяжуулж өгдөг.

Түүнчлэн санхүүгийн шинжилгээ нь удирдлагын шинжлэх ухааны, ялангуяа санхүүгийн менежментийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Удирдлагын процесст шинжилгээний гүйцэтгэх үүрэг, хэрэгцээ шаардлагыг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

1. Компанийн үйлдвэрлэлийн нөөц болон түүний өөрчлөлт, ашиглалтын үр ашгийг үнэлэх
2. Хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд удирдлагын шийдвэр гаргалтын үндэслэлийг сайжруулах
3. Компанийн ашгийн динамик өөрчлөл, хэтийн төлвийг үнэлэх зэрэг болно.

Энэ хэрэгцээ шаардлагыг хангахын тулд мэдээллийн агуулга ба хэрэглээний хувьд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тайлан бэлтгэх явдал чухал юм. Иймээс нягтлан бодогчийн бэлтгэж байгаа санхүүгийн тайлангийн тоо мэдээ нь удирдлагын шийдвэр гаргах ба шинжилгээ хийхэд чухал хэрэгтэй, ашигтай чанарыг өөртөө агуулсан байх ёстой.

Санхүүгийн шинжилгээ нь маркетингийн шинжлэх ухаантай ихээхэн холбоотой. Зах зээлийн чөлөөт эдийн засаг, түүний зохион байгуулалт, удирдлага нь нягт нямбай боловсруулсан маркетингийн хөтөлбөргүйгээр, маркетингийн зарчмуудыг ашиглахгүйгээр хэрэгжих боломжгүй юм. Ялангуяа маркетингийн хөтөлбөрийн боловсруулалт, түүний гүйцэтгэл нь шинжилгээний холбогдох тооцоололтой нягт холбоотой байдаг. Дараах судалгаа шинжилгээ нь маркетингийн хөтөлбөр ба түүний хяналтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнд:

1. Компанийн эдийн засгийн гадаад ба дотоод орчны нөлөөллийг шинжлэх
2. Зах зээлийн нөхцөл байдлыг судлах
3. Худалдан авагч ба хэрэглэгийг судлах
4. Өрсөлдөх чадварыг судлах
5. Зах зээлийн үнэ ба өөрийн үнэ бүрдэлтийг шинжлэх
6. Санхүүгийн эцсийн үр дүнг шинжлэх зэрэг болно.

Дээрх байдлыг дүгнэж үзвэл санхүүгийн шинжилгээ нь нягтлан бодох бүртгэл, статистикийн мэдээлэл дээр тулгуурлан бүртгэл, шинжилгээ, математик, статистикийн аргуудыг ашиглан хийгдэж шийдвэр гаргах, төлөвлөх, зохион байгуулах, хянах зэрэг удирдлагын функцийг хэрэгжүүлэх, маркетингийн хөтөлбөр түүний хяналтыг гүйцэтгэх, улмаар санхүүгийн тайлангийн аудитыг амжилттай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Энэ утгаараа санхүүгийн шинжилгээ нь мэдээллийн системд чухал байр суурь эзэлж хэрэглэгчдийг нэн шаардлагатай мэдээллээр хангахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг байна.

Дүгнэлт

Нягтлан бодох бүртгэлийн данс, дансны давхар бичилтийн аргыг 13-р зууны үед үүссэн гэж үздэг бол бүртгэл, тайлангийн тоо мэдээг шинжлэх арга зүй түүнээс даруй 400-гаад жилийн хойно үүсэж хөгжсөн байна. Харин Монгол улсад 1921 оноос Аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээний арга зүйг, 1990 оноос Санхүүгийн шинжилгээний арга зүйг тус тус ашиглан бүртгэл тайлангийн тоо мэдээллийг боловсруулж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, улмаар үр ашигтай удирдах арга хэрэгсэл болгон ашиглаж ирсэн. Цаашид шинжилгээний арга зүйг улам боловсронгуй болгох, бүртгэлийн мэдээлэл хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад нь шаардлагатай мэдээллийг шуурхай бэлтгэхэд орчин үеийн математик, статистикийн аргуудыг өргөнөөр ашиглах нь мэдээллийн үнэ цэнэ, ач холбогдлыг улам нэмэгдүүлнэ.

Ашигласан материал

Баканов М.И., Шеремет А.Д. *Теория экономического анализа* М, Финансы и статистика М, 1997

Бочарев В.В. *Финансовое моделирование* – СПб.: Питер, 2020.

Жак Ришар *Аудит и анализ хозяйственной деятельности предприятия* перевод с французской под ред Л.П.Белых. М.Аудит, ЮНИТИ 1997

Ковалев В.В. *Финансовый анализ: Управление капиталом. Выбор инвестиций*

Анализ отчетности. – М.: Финансы и статистика, 1996, 1998

Ковалев В.В. *Введение в финансовый менеджмент* – М.: Финансы и статистика, 2004.

Ковалев В.В., Ковалев Вит.В. *Финансы предприятий: Учеб.* – М.: ТК

- Велби, Изд-во Проспект, 2004. с.125
- Ендовицкий Д. А. *Комплексной анализ и контроль инвестиционной деятельности* – М.: Финансы и статистика, 2001
- Панков Д. А. *Бухгалтерский учет и анализ в зарубежных странах : Учебное пособие* Минск. Экоперспектива, 1998
- Радионов Н.В., Радионова С.П, *Основы финансового анализа* СПб. 1999
- Сергеев И.В. “Экономика предприятия: Учеб. пособие. 5-е изд, перераб. и доп. – М. : Финансы и статистика, 2015. -304 с. : ил. с.134
- Томас П. Карлин, Альберт Р.Маклин, *Анализ финансовых отчетов / на основе СААР/*, М.1999
- Чечевицына Л.Н., Чуев И.Н. *Экономика фирмы: Учебное пособие для студентов вузов.* – Ростов н/Д : Феникс, 2018. с. 85
- Шеремет А.Д, Сайфулин Р.С, *Методика финансового анализа* Инфра М, 1995
- Лхамсүрэн Л., Мирощенко С.М. *Аж үйлдвэрийн аж ахуй санхүүгийн ажиллагааны шинжилгээ ба шалгалт.* 1959. УБ
- Түмэн Ч. *Үйлдвэрийн нягтлан бодох бүртгэлийн сурах бичиг.* 1949. УБ
- Түмэн Ч., Занабазар Л. *Үйлдвэрийн газрын аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ.* 1959. УБ
- Helfert, E.A. 1994. *Techniques of Financial analysis.* IRWIN. pp.15
- Foster, G. *Financial statement analysis.* Second edition. Stanford University press. 1986
- Haskins, M.E., Ferris, K.R., Selling, T.I., Samuels J.R., Ebrayshaw J .M. *International Financial Reporting and Analysis A. Contextual Emphasis.* 1996
- 西村吉正 (2011) 『金融システム改革50年の軌跡』、金融財政事情研究会
- 森信茂樹 (2010) 『日本の税制:何が問題か』、岩波書店